

# БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ТУЛПАР ХК

2025 оны 02 дугаар  
сарын 19-ны өдөр

№ 04

Өлгий сум

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Тулпар ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаас хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлан хуралдуулах тухай асуудлаар хэлэлцэж, олонхийн саналыг үндэслэн ТОГТООХ нь :

1. Тулпар ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 15:00 цагт Баян-Өлгий аймгийн Өлгий сумын 13-р багийн Тулпар ХК-ны байр сургалтын танхимд зарлан хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэхээр оруулсугай.
  - 2024 оны компанийн санхүүгийн тайлангийн тухай
  - 2024 оны компанийн үйл ажиллагааны тайлан
  - ТУЗ-ийн гишүүдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулан сонгох
  - 2025 оны зорилт, бусад асуудал
  - Ногдол ашиг тараахгүй тухай ТУЗ-ийн шийдвэр
  - Компанийг өөрчлөн байгуулах төсөл /ХК-г ХХК болгон өөрчлөх/
  - Бусад
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2025 оны 03 дугаар сарын 11-ны өдрөөр тогтоосугай.
4. Компанийн ээлжит хурлыг хуралдуулах шийдвэр гарсантай холбогдуулан хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд хурлын зарыг хүргэхээр 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрөөр өдөр тутмын 2-оос доошгүй сонин болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэх. Энэ мэдээллийг дээрхи хэлбэр шаардлагын дагуу анх мэдээлсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа дахин мэдээлж хөрөнгийн биржийн цахим хуудсанд тавихыг хурал зохион байгуулах комисст даалгасугай.

5. Ээлжит хурлын дэгийг 01 дүгээр хавсралтаар, хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчид нь энэхүү шийдвэрийн 02 дугаар хавсралтанд заасан бичиг баримтыг ажлын өдрүүдэд 09:00-17:00 цагийн хороонд Тулпар ХК-ны байранд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга С.Нурланаас танилцах эрхтэй болохыг дурдсугай.
6. Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс хэлэлцэх асуудлаар санал авах "Саналын хуудас" -ын агуулгыг 03 дугаар хавсралтаар баталсугай.
7. Хувьцаа эзэмшигчдээс санал авах хуудсыг хүлээн авах сүүлийн өдрийг харьяалагдах брокер, дилерийн компаниар дамжуулан хурал хуралдах өдрөөс ажлын 5-аас доошгүй хоногийн өмнө байхаар тогтоосугай.
8. Компанийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.6 -д заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдах үед хувьцаа эзэмшигчдийг компанийн холбогдох бичиг материалтай танилцуулахыг ТУЗ-ын нарийн бичгийн дарга С.Нурланд даалгасугай.

ТУЗ-ийн дарга



М.Жанатхан